



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/520

Булган сум

Газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 29 дүгээр зүйлийн 29.10.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Х.Номин-Эрдэнэ (ГЮ00251402)-ийн эзэмшиж буй Булган сум 6 дугаар баг Залуус 3 дугаар гудамж 303а тоотод байршилтай 6308009828 нэгж талбарын дугаар бүхий амины орон сууцны зориулалттай 555 м2 газар нь “Ус, цаг уур, орчны шинжилгээний төв”-ийн ажиглалтын талбайн хамгаалалтын бүсэд орсон тул Булган сум 6 дугаар баг Залуус 2 дугаар гудамж 212а тоотод байршлыг өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Газрын кадастрын мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг хийж, газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР